



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/57

Хэрлэн сум

Сар шинийн баярт зориулсан үндэсний
бөхийн барилдааны зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.1, 10.1.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Биеийн тамир, спортын газрын спорт цогцолборт 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдах Арван долдугаар жарны "АЛТАН УНЖЛАГАТ" хэмээх гал тахиа жилийн сар шинийн баяр, аймгийн "НАЧИН" цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд зориулсан үндэсний бөхийн барилдааны зардалд 5578000 /Таван сая таван зуун далан найман мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

Хоёр. Дээрх зардалд шаардагдах 5578000 /Таван сая таваг зуун далан найман мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

Гурав. Аймгийн "НАЧИН" цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд зориулсан үндэсний бөхийн барилдааныг өндөр түвшинд зохион байгуулахыг Биеийн тамир, спортын газар/ Г.Нэргүйбаатар/-т, даалгасугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 347

**Аймгийн начин цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд зориулсан үндэсний
бөхийн барилдааны шагнал, шүүгчдийн зардлын төсөв**

Бөхийн шагнал /насанд хүрэгчид 128 бөх/

1. Түрүү бөх 1 x 300000 = 300000
2. Үзүүр бөх 1 x 250000 = 250000
3. Шөвгийн бөх 2 x 150000 = 300000
4. 4 давсан бөх 4 x 60000 = 240000
5. 3 давсан бөх 8 x 50000 = 400000
6. 2 давсан бөх 16 x 20000 = 320000
7. 1 давсан бөх 32 x 10000 = 320000

Бүгд-2130000

Засуул шүүгчид

1. Засуул 10 x 20000 = 200000
2. Гарын даа 2 x 30000 = 60000
3. Хөлийн цэц 2 x 30000 = 60000
4. Нэвтрүүлэгч шүүгч /хөтлөгч/ 2 x 50000 = 100000
5. Эмч шүүгч 1 x 20000 = 20000
6. Узелийн ажилтан 1 x 20000 = 20000

Бүгд - 460000

Бусад зардал

1. Идээний боов 30ш x 2000 = 60000
2. Ааруул 2 кгх 12000 = 24000
3. Ёотон 2 хайрцагх 2000 = 4000
4. Өргөмжлөл А4 4 x 10000 = 40000
5. Хадаг 8 x 2000 = 16000
6. Урилга 80ш x 2000 = 160000
7. Аймгийн начин цолтой бөхчүүдэд хүндэтгэл 80 хүн x 10000 = 800000
8. Үндэсний бөхийн холбооны хурлын төлөөлөгчдөд зориулсан цайллага 100 хүнх 15000 = 1500000
9. Зар сурталчилгааны баннер 6x8 = 48м2 48 x 8000 = 384000

Бүгд -2988000

Нийт зардал – 5578000